



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 12 өдөр


Дугаар 18

Бөхт

Сумын ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын ИТХ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг ИТХ-ын Хороодод үүрэг болгосугай.
3. Журмыг нийтэд сурталчилж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид болон нарийн бичгийн дарга Д.Уранбилэг нарт даалгасугай.



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04-р сарын
12-ны өдрийн 18-р тогтоолын хавсралт

ИТХ-ААС ГАРГАСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭЖЖИЛТЭНД ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нийтийн сонсголын тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай ба Захиргааны өрөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудыг үндэслэл болгоно.

Хоёр. ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан энэхүү журмын зорилго

2.1. ИТХ-аас батлан гаргасан шийдвэрийн заалт бүр бодит ажил болж, тухайн ороон нутгийн хэмжээний эдийн засаг, нийгмийн зорилтыг шийдвэрлэж хэрэгжүүлэх, хөгжлийг түргэтгэх, иргэдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах ажлыг чанаржуулахад оршино.

Гурав. Үйл ажиллагааны зарчим

3.1. Шударга, ил тод байх

3.2. Хууль дээдлэх

3.3. Хариуцлагатай байх

3.4. Төлөөлөгч, Иргэдийн оролцоог хангах

Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлэлт дүгнэлтийн ажлын зохион байгуулалт

4.1. Хурал болон Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэр бүрийг ил тод байлгаж, нийтэд мэдээлэх, иргэний танхимаар сурталчлах,

4.2. Хурлаас гаргасан тогтоол, хөтөлбөр, журам бүрд карт нээж, заалт хэсэг бүрээр нь хариуцах эзэн, гүйцэтгэх хугацааг тодорхойлсон цахим сан үүсгэж хяналт тавих,

4.3. Хурлын шийдвэрийг хэлэлцэн батлахын өмнө гарах үр дүн, хэзээ дүгнэх, хэн хариуцах үзүүлэлтээ урьдчилан тооцсон шалгуур үзүүлэлтээ тогтоох,

4.4. Хурлын хороо нь өөрийн хариуцсан чиг үүргийг хүрээнд Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийх,

4.5. Хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн хүмүүс болон иргэдийн төлөөллийг оролцуулах.

Тав. Хурал, Тэргүүлэгчид, Хорооны чиг үүрэг.

5.1. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө гаргах,

- 5.2. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх түр хороо, ажлын хэсэг байгуулж удирдамжтайгаар ажиллуулах,
- 5.3. Холбогдох зардал болон ажиллах нөхцөлийг хангах,
- 5.4. Хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын дүнг Хурал, Тэргүүлэгчдээр хэлэлцэх, зөвлөмж чиглэл гаргах, холбогдох газарт хүргүүлэх,
- 5.5. Хороо, түр хороо, ажлын хэсэгт тодорхой чиглэл өгч, хяналт шинжилгээ хийлгэх,
- 5.6. Хурлаас баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах,
- 5.7. Хурлын хороо, ажлын хэсэг нь Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнд судалгаа явуулж, иргэдээр үнэлүүлж, дүгнэлт хийх,
- 5.8. Хурлын хороо нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ажилдаа хорооны ажиллах журмыг баримтлан ажиллах,
- 5.9. Хурлын хороо Хурлаас батлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ шаардлагатай албан тушаалнаас холбогдох мэдээллийг авах,
- 5.10. Санал дүгнэлтийг тогтоосон хугацаанд гарган Хурал, Тэргүүлэгчдэд танилцуулах.

Зургаа. Хурлын ажлын албаны үүрэг

- 6.1. Хяналт хийх аливаа асуудлаар Төлөөлөгч, Хороодын санал авч, төлөвлөгөөнд тусгах,
- 6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг хамрах хүрээ, оролцох төлөөлөл, ажиллах хугацаа, дүгнэх асуудлаа урьдчилан боловсруулах,
- 6.3. Төлөөлөгч болон холбогдох хүмүүст арга зүйн зөвлөгөө өгөх,
- 6.4. Дүнг гаргах, шаардлагатай хуралд танилцуулах бэлтгэлийг хангах,
- 6.5. Хяналтын чиглэлээр гарсан шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэх.

Долоо. Иргэд, олон нийтийн оролцоо

- 7.1. Хурлын байгууллагаас гаргасан шийдвэртэй танилцах,
- 7.2. Хурлын байгууллагын гаргасан шийдвэрийн биелэлтийг шаардах,
- 7.3. Шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын хэсэгт оролцох,
- 7.4. Ажлын хэсгийн санал дүгнэлтэд саналаа тусгах.

Найм. Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг.

- 5.2. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх түр хороо, ажлын хэсэг байгуулж удирдамжтайгаар ажиллуулах,
- 5.3. Холбогдох зардал болон ажиллах нөхцөлийг хангах,
- 5.4. Хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын дүнг Хурал, Тэргүүлэгчдээр хэлэлцэх, зөвлөмж чиглэл гаргах, холбогдох газарт хүргүүлэх,
- 5.5. Хороо, түр хороо, ажлын хэсэгт тодорхой чиглэл өгч, хяналт шинжилгээ хийлгэх,
- 5.6. Хурлаас баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах,
- 5.7. Хурлын хороо, ажлын хэсэг нь Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнд судалгаа явуулж, иргэдээр үнэлүүлж, дүгнэлт хийх,
- 5.8. Хурлын хороо нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ажилдаа хорооны ажиллах журмыг баримтлан ажиллах,
- 5.9. Хурлын хороо Хурлаас батлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ шаардлагатай албан тушаалнаас холбогдох мэдээллийг авах,
- 5.10. Санал дүгнэлтийг тогтоосон хугацаанд гарган Хурал, Тэргүүлэгчдэд танилцуулах.

Зургаа. Хурлын ажлын албаны үүрэг

- 6.1. Хяналт хийх аливаа асуудлаар Төлөөлөгч, Хороодын санал авч, төлөвлөгөөнд тусгах,
- 6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг хамрах хүрээ, оролцох төлөөлөл, ажиллах хугацаа, дүгнэх асуудлаа урьдчилан боловсруулах,
- 6.3. Төлөөлөгч болон холбогдох хүмүүст арга зүйн зөвлөгөө өгөх,
- 6.4. Дүнг гаргах, шаардлагатай хуралд танилцуулах бэлтгэлийг хангах,
- 6.5. Хяналтын чиглэлээр гарсан шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэх.

Долоо. Иргэд, олон нийтийн оролцоо

- 7.1. Хурлын байгууллагаас гаргасан шийдвэртэй танилцах,
- 7.2. Хурлын байгууллагын гаргасан шийдвэрийн биелэлтийг шаардах,
- 7.3. Шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын хэсэгт оролцох,
- 7.4. Ажлын хэсгийн санал дүгнэлтэд саналаа тусгах.

Найм. Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтны чиг үүрэг.

8.1. Хурлын байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажилд мэргэжлийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх

8.2. Хурлын шийдвэрийн биелэлт үр дүнгийн талаар тайлан, мэдээ, судалгаа гаргаж Хуралд ирүүлэх,

8.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Хурлын шийдвэрийн жагсаалтыг гаргаж Төлөөлөгч, холбогдох байгууллагад бүрэлдэхүүнд өгөх,

8.4. Ажлын хэсгийн санал дүгнэлтэд мэргэжлийн зүгээс саналаа өгөх,

8.5. Хурлын байгууллагаас гаргасан шийдвэрийг иргэдэд сурталчлах, таниулах.

Ес. Хяналт шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээ, гаргасан үр дүнгийн талаар мэдээлэх, тайлагнах.

Хяналт шинжилгээний үр дүнгийн тайланг аль шатны ямар хурал, зөвлөгөөнөөр хэлэлцүүлэхээс урьдчилан буюу шалгалтын дараа тогтооно. ҮҮНД:

9.1. ИТХ-ын хуралдаанаар,

9.2. Тэргүүлэгчдийн хуралдаанаар,

9.3. Ажлын хороогоор,

9.4. Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хамтарсан хурлаар,

9.5. Баг, хорооны ИНХ-аар,

9.6. Байгууллагын хамт олны хурал зөвлөгөөнөөр хэлэлцүүлэх.

Арав. Хүрэх үр дүн

10.1. Хуралдаж хэлэлцсэн шийдвэр бүр бодит ажил болно.

10.2. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянаж дүгнэсээр хариуцлага өндөржине.

10.3. Хурлын төлөөлөгч, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

10.4. Шийдвэрийн хэрэгжилт үр дүнд чиглэгдэнэ.

10.5. Хурлын байгууллагын нэр хүнд, байр суурь, үнэлэмж нэмэгдэнэ.

10.6. Шийдвэр гаргахдаа биелэлт, үр дүнгээ тогтоох шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлж хэвшина.

10.7. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг тогтолцоо хэвшиж сайжирна.

10.8. Хурлаас гаргасан шийдвэрийн буртгэл хяналт чанаржина.

Арваннэг. Хориглох зүйл.

11.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулахдаа байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хохирол учруулах,

11.2. Хяналт шалгалтын явцад олж авсан байгууллага, хувь хүний нууцыг задруулах,

11.3. Хяналт шалгалтын явца ашиг сонирхлын зөрчил үүссэн бол хяналт шалгалтын үйл ажиллагаанд оролцохос татгалзах.

Арванхоёр. Хариуцлага хүлээлгэх

12.1. Холбогдох албан тушаалтан мэдээлэл, ажлын тайланг Тэргүүлэгчид, эсвэл хорооны хурлаар хэлэлцэж чиглэл өгөх.

12.2. ИТХ-ын байгууллагаас гаргасан шийдвэр, өгсөн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, мэдээлж тайлагнаагүй, ажилтан, албан тушаалтны талаар дээд шатны удирдлагад нь мэдэгдэж хариуцлага тооцуулах.

12.3. Хурлын шийдвэрт хариуцлагагүй хандсан, өгсөн чиглэл үүргийг удаа дараа биелүүлээгүй албан тушаалтны хөдөлмөрийн гэрээг цуцлах асуудлаар холбогдох удирдлагад уламжлах.

СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД